

6

Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого

УДИРТГАЛ 60

- | | | |
|----|--------------------------------|----|
| 1. | Бодлогын баримт бичгийн дугаар | 60 |
| 2. | Зорилго | 60 |
| 3. | Хамрах хүрээ | 61 |
| 4. | Мөрдөж эхлэх хугацаа | 61 |
| 5. | Бүрэн эрх, удирдлага | 61 |

БОДЛОГО 62

- | | | |
|----|------------------------------------|----|
| 1. | Эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт | 62 |
| 2. | Үндэсний нийлүүлэгчдийн онцлог | 62 |
| 3. | Үндэсний нийлүүлэгчдийг хөгжүүлэх | 65 |
| 4. | Тайлагнах шаардлага | 67 |

Удиртгал

1. Бодлогын баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичгийг ХААБ-07: **Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх тухай бодлого** гэж нэрлэнэ.

2. Зорилго

Энэхүү бодлогыг үндэсний нийлүүлэгчидтэй хамтран ажиллах, тэднийг дэмжих, хөгжүүлэх тухай Оюу Толгой ХХК-ийн үүрэг, амлалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсруулав.

Түүнчлэн дор дурдсан зүйлсийн талаарх ойлголтыг тодорхой болгоно. Үүнд:


- Үндэсний нийлүүлэгч гэх тодорхойлолтод нийцсэнийг илтгэх эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт
- Нөөц баялгийн салбарын хэрэгцээ, шаардлагын талаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлагад үндэслэн Оюу Толгой ХХК-аас боловсруулсан үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх санаа, санаачлагууд;
- Оюу Толгой ХХК-ийн ажилтнуудад тавигдах тайлагналын шаардлага зэрэг болно.

Энэ бодлого нь дараах давхар зорилтыг хэрэгжүүлэхэд Оюу Толгой ХХК-д дэмжлэг болно. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн дотоодын нийлүүлэгчдийг хөгжүүлэх, дэмжихтэй холбоотой үүрэг амлалтаа биелүүлэх;
2. Оюу Толгой ХХК-ийн уурхайн ашиглалтын хугацааны хэрэгцээ, шаардлагыг Монгол Улсын нутаг дэвсгэрээс хангах урт хугацааны, тогтвортой, дотоодын хангамжийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх явдал юм.

Зураг 1-д харуулснаар, ХААБ 07: Үндэсний нийлүүлэгчдийг дэмжих, хөгжүүлэх талаар баримтлах бодлого нь Оюу Толгой ХХК-ийн Худалдан авах ажиллагаанд баримтлах үндсэн найман бодлогын нэг нь юм.

Зураг 1: Оюу Толгой ХХК-ийн худалдан авах ажиллагааг удирдан зохицуулах үндсэн бодлогын баримт бичгүүд



3. Хамрах хүрээ

Энэ бодлогыг:

- Оюу Толгой ХХК-ийн бүх ажилтнууд
- “Үндэсний” гэх тодорхойлолтод нийцэх бүх эрх бүхий нийлүүлэгчид (1-р Хэсэг: Үндэсний нийлүүлэгч болохыг тодорхойлох Оюу Толгой ХХК-аас тавьж буй эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт-д заасны дагуу).

4. Мөрдөж эхлэх хугацаа

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогыг 2012 оны 11-р сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5. Бүрэн эрх, удирдлага

Энэхүү шинэчлэн найруулсан бодлогын баримт бичгийг Оюу Толгой ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2012 оны 11-р сарын 20-ны өдөр батлав.

Энэхүү баримт бичгийг жил бүр эсхүл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хянан засварлана.

Оюу Толгой ХХК-ийн Хангамж, Дэд бүтцийн хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч нь тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хариуцна. Энэхүү бодлогод өөрчлөлт оруулах аливаа санал хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах бөгөөд тэрээр зохих ёсоор хянан, батална.

Бодлого

1. Эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлт

Энэхүү бодлогын зорилгын хүрээнд Үндэсний нийлүүлэгч гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, үйлчилгээ нийлүүлж байгаа нийлүүлэгчийг хэлнэ.

Дээрх тодорхойлолтод хамаарах шаардлагуудыг хангахуйц бараа нийлүүлж, үйлчилгээ үзүүлж чадах нийлүүлэгчид нь нь Оюу Толгой ХХК-аас хэрэгжүүлэх дор дурдсан бодлогын хүрээнд зохих байдлаар боломж хүртэх, дэмжлэг авах хөтөлбөрт хамрагдах эрх бүхий байна.

Үндэсний нийлүүлэгчийн ангилалд багтахын тулд тухайн аж ахуй нэгж нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Монгол Улсад бүртгэлтэй компани байх;
- Компаний 50-иас дээш хувийг Монгол улсын иргэн эзэмшдэг байх зэрэг болно.

Оюу Толгой ХХК нь дотоодын нийлүүлэгчдийг Зураг 2-т үзүүлсэн хөгжлийн үе шатны хамгийн дээд түвшинд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор уг бодлогыг тухайн үеийн зах зээлийн өөрчлөлттэй уялдуулан жил бүр хянан засварлаж, шинэчлэнэ.

2. Үндэсний нийлүүлэгчдийн онцлог

Үндэсний нийлүүлэгчид нь Өмнөговийн бүсийн нийлүүлэгчдийг бодвол харьцангуй төлөвшсөн байдаг ч нөөц баялгийн салбарын хэрэгцээ, шаардлагын талаар ойлголт багатай байсаар байна. Энэ байдал нь Оюу Толгой ХХК-ийн худалдан авах хэрэгцээ, шаардлагыг хангах өрсөлдөөнт тендер шалгаруулалтад амжилттай оролцоход нь саад болж буй нь олон жишээгээр харагдаж байна.

Энэхүү бодлогод үндэсний нийлүүлэгчдийг эрчимтэй хөгжиж байгаа нөөц баялгийн салбар, аж үйлдвэрлэлийн стандартыг хангаж ажиллах, хөрвөх чадвартай болж хөгжих үйл явцыг нь хурдасгахад нь Оюу Толгой ХХК-ийн зүгээс дэмжин ажиллах боломжит чиглэлүүдийг тодорхойлох тухай авч үзсэн болно.

Үүний тулд энэ бодлого нь үндэсний нийлүүлэгчдийн одоогийн байдлаар эдлэх давуу эрхийг тодотгон зүй зохистой байдлаар дэмжлэг үзүүлж буй эсэхийг тодорхойлох үүднээс Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчдэд тулгардаг бэрхшээл, тэдгээрийн нийтлэг шинж болон онцлог чанарыг тогтоосон болно. Монгол Улсын үндэсний нийлүүлэгчид нь ихэвчлэн дор дурдсан онцлогтой. Үүнд:

- Гадаадад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, эсхүл импортоор оруулж ирсэн бараа бүтээгдэхүүнийг дамжуулан борлуулагч эсхүл зуучлагчийн

- үүрэг гүйцэтгэх түвшинд үйл ажиллагаагаа явуулдаг. (Тухайлбал Тоног Төхөөрөмжийн Үндсэн Үйлдвэрлэгч (ОЕМ)-ийн Монгол дахь гэрээт төлөөлөгчийн газраар ажиллах гэх мэт);
- Дийлэнх аж ахуйн нэгжүүд нь үйлчилгээний салбарт ажиллаж эсхүл үйлчилгээтэй холбоотой чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна;
 - Үйлдвэрлэл эрхлэн явуулах чадавхи нь хөгжлийн явцдаа байна;
 - Өмнөговийн бизнес эрхлэгчидтэй харьцуулахад ажил хэрэг явуулах ерөнхий арга хэлбэрийн хувьд (гэрээний нөхцөл, шаардлага) илүү төлөвшсөн хэдий боловч тэргүүн туршлагын хэмжээнд хүрээгүй байна;
 - Хүчин чадал хязгаарлагдмал, ялангуяа барилга угсралтын ажил үйлчилгээ, аж үйлдвэрлэлийн салбарын хувьд хангалтгүй хүчин чадалтай;
 - Бэлтгэн нийлүүлэлтийн зарим чадварыг эзэмшсэн боловч цогц хангамжийн сүлжээний аюулгүй, баталгаатай байдал болон чадавхийн хувьд хөгжлийн үе шатандаа байна;
 - Бэлэн мөнгөний хомсдолтой буюу бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн баталгаа гаргахад шаардагдах эх үүсвэрийн хувьд бэрхшээлтэй тулгардаг зэрэг болно.


Зураг 2-т Монгол Улсын нэгэн адил хөгжиж буй орнуудын хувьд нийлүүлэгчдийн хөгжлийн нийтлэг дүр зургийг илтгэх муруйг харуулав. Үүний зорилго нь томоохон өртөг бүхий буюу олон улсын түвшний гадаадын нийлүүлэгчдээс хараат бус, бие даан хөгжиж буй компанийг илүү өндөр түвшинд хүрч төлөвшсөн нэгэн болж хөгжих Үндэсний нийлүүлэгчдийн урт хугацааны хөгжлийн шатыг харуулахад оршино. Монгол Улсад одоогоор дор дурдсан ангилал бүрт хамаарах жишээ байгаа бөгөөд илүү тодорхой болгох үүднээс холбогдох тайлбарыг оруулав.

- Хөгжлийн 1-р үе шат – Олон улсын түвшний/Гадаадаас нийлүүлэлт хийгдэх–Монгол Улсын хувьд аж үйлдвэрийн салбар нь харьцангуй шинэ тутам ба хөрөнгийн шинэчлэлийн томоохон хөтөлбөрүүд хэрэгжсэнээр хөгжих эхлэлээ тавьж буй энэ үед гаднаас нийлүүлэлт хийгдэх нь хэвийн үзэгдэл юм. Оюу Толгой ХХК-ийн хувьд Оюу Толгой төслийн хүрээнд томоохон хэмжээний дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажил явуулж байгаатай холбогдуулан Инженерийн болоод Худалдан авалт, Барилга угсралт (ИХБ)-ын ажлын цогц үйлчилгээ үзүүлдэг компаниуд, барилга угсралтын томоохон төсөл хэрэгжүүлэх чадвартай компаниуд болон ган үийцийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зэрэг салбарт гадаадын эх үүсвэрээс авч ажиллаж байна.
- Хөгжлийн 2-р үе шат
 - Бараа, үйлчилгээг нийлүүлэх, худалдаалахад гэрээт борлуулагч буюу төлөөлөгчийн газар байгуулан ажиллах явдал түгээмэл байдаг. Энэ нь ерөнхийдөө үндэсний компаниуд тухайн бизнесийн салбарын өсөлтийг олж харан тэдгээр бараа, үйлчилгээг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийлүүлэх зорилгоор аливаа нэг гадаадын компанийн гэрээт борлуулагч/төлөөлөгч эсхүл итгэмжлэгдсэн түнш болж хамтран ажиллах тухай юм. Тухайлбал, уул уурхайн салбарын техник, тоног төхөөрөмж гаднаас оруулж ирдэг

томоохон компаниуд зэрэг олон жишээ дурдаж болно. Өөр нэгэн түгээмэл байгаа жишээ бол гадаадын бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг олж харан тухайн үйлдвэрлэгчийг төлөөлөх ямар нэгэн тусгай эрхгүйгээр, хэрэглэгч, үйлдвэрлэгч хоёрын хооронд албан бус зуучлагчийн үүрэг гүйцэтгэн, худалдаа эрхэлж байгаа компаниуд юм. Иймд, тухайн тохиолдлоос шалтгаалаад албан ёсны худалдааны төлөөлөгчийн орон зайд ажиллаж байгаа зуучлагчаас Монголын эдийн засагт оруулж буй хувь нэмэр, үнэ цэнийн талаар болгоомжтойгоор анхаарч үзэх шаардлагатай.

- Гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсад оюуны өмч (технологи) оруулж ирэх хэдий боломжтой боловч Монголын зах зээлийн орон зайд үүнийг шууд нэвтрүүлэхэд бэлэн бус, төвөгтэй байдаг тул Хамтарсан хөрөнгө оруулалттай Монголын компаниуд олноор бий болж байна. Хамтарсан хөрөнгө оруулалттай компани болох нь жирийн гэрээт төлөөлөгчийн газартай харьцуулахад хөгжлийн илүү дэвшилттэй үе шат бизнесийн төлөвшин тогтох үйл явц юм. Оюу Толгой ХХК-ийн хувьд бэлтгэн нийлүүлэлт (ложистик), барилга угсралт, уул уурхайн томоохон тоног төхөөрөмжийн салбарт дээрх жишээнүүд бий. Хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд ажиллах хүчнийхээ дийлэнхийг дотоодоос бүрдүүлж, дотоодод суурилсан хөрөнгө оруулалт хийхэд хүчин чармайлт гарган, үүрэг амлалт хүлээн ажиллах аваас Монголын эдийн засагт чухал хувь нэмэр оруулах боломжтой.
- Хөгжлийн 3-р үе шат – Бие даасан, хараат бус Монгол компани – энэ нь ерөнхийдөө оюуны өмч (технологи) Монголд шилжин ирсэн эсхүл тэр нь Монголд байдаг ба дотоодын ажиллах хүчин, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүх салбарт өөрсдөө оролцож буй хөгжлийн үе шат юм. Энэхүү хөгжлийн 3-р үе шатан дахь компаниуд нь анхны хөрөнгө оруулалт, төслийн цар хүрээ ба хэмжээ, тогтвортой хөгжлийн хандлагын хувьд тодорхой бус зэрэг байдлаас хамааран 2-р үе шатны Хамтарсан хөрөнгө оруулалттай компанитай харьцуулахад үйл ажиллагааны хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал байж болно.
- Хөгжлийн 4-р үе шат – Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төлөвшиж тогтворжсон Монгол компани – Хөгжлийн энэ түвшинд хүрсэн компаниуд нь гадаад, дотоодын зах зээлээс түүхий эдээ авдаг, өөрсдийн худалдаа, маркетинг, бүтээгдэхүүний шинэчлэл, боловсруулалт, бэлтгэн нийлүүлэлт гэх мэт бүх төрлийн сувгаараа хэрэглэгчдэдээ бараа үйлчилгээгээ хүргэдэг, өөрийн хөрөнгийн эх үүсвэр бүхий үйлдвэрлэгчид байдаг. Эдгээр компаниудын хувьд анхны хөрөнгө оруулалтын бэрхшээлийг ерөнхийдөө даван туулж чадсан байх бөгөөд цаашдын тогтвортой хөгжлийг тодорхойлох дотоодын эрэлт хэрэгцээ нь хангалттай байдаг. Энд Монголын цемент, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, агаарын тээвэр, газрын тээвэр, эрүүл мэнд, харуул хамгаалалт гэх мэт үйлчилгээний салбаруудад байгаа жишээг дурдаж болно.

Зураг 2. Нийлүүлэгчдийн хөгжлийн үе шат



Хэрэв нийлүүлэгчид нь бүх шалгуур үзүүлэлт, чадварын шаардлагыг нэгэн зэрэг ижил хангаж байх тохиолдолд Оюу Толгой ХХК нь Монгол Улсын эдийн засагт оруулах бодит үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хөгжлийн илүү өндөр шатанд байгаа үндэсний нийлүүлэгчийг сонгохыг эрхэмлэнэ.

3. Үндэсний нийлүүлэгчдийг хөгжүүлэх

Оюу Толгой ХХК нь Монгол Улсын үндэсний нийлүүлэгчдийн өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор дор дурдсан арга замуудыг ашиглана. Үүнд:

- 1. Гэрээ хэрэгжүүлэх чадварыг бэхжүүлэх:** Үндэсний олон тооны нийлүүлэгчдийн хувьд гэрээ хэрэгжүүлэх чадвар, чадавхи одоо хэр нь хөгжлийн шатандаа байна. Үндэсний нийлүүлэгчид нь нөөц баялгийн салбарын хэрэгцээ, шаардлагын талаар илүү өндөр мэдлэг боловсролтой болоход суралцах, хөгжлийн дэмжлэг туслалцаа авах шаардлагатай байгаа нь олон жишээнээс харагдаж байна. Иймээс Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг хянах явцдаа тэдэнд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, бизнесийн хөгжил, чанарын баталгаажилт, үйлчилгээний нөхцөл зэрэг чиглэлүүдээр чадавхижуулж, сургах шаардлагатайг бүрэн ойлгож үүнийг хэрэгжүүлэхээр зорьж буй болно. Ингэснээр үндэсний нийлүүлэгчид нь тухайн бараа, үйлчилгээний хувьд гадаадын нийлүүлэгчидтэй өрсөлдөхөд харьцангуй өндөр чадвар, боломжтой болно. Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэх явцдаа Оюу Толгой ХХК-тай хамтын ажиллагаагаа хэвээр хадгалах, түүнчлэн цаашдын хөгжил дэвшилд шаардагдах зөв хөшүүрэг бий болгож бүтээлчээр хамтран ажиллахын тулд тухайн нийлүүлэгчийн хувьд анхаарч шийдвэл зохих аливаа сул тал, асуудлуудыг тодорхойлно.
- 2. Худалдан авалтын болон нийлүүлэгчдийн төрөл:** Оюу Толгой ХХК нь зарцуулалтын буюу худалдан авалтын талаар мэдээллийг ангилал,

төрлөөр нь 12 сар тутам гаргаж нээлттэй, ил тод мэдээлэх бөгөөд үүнд мөн Монгол улсын дотоодын нийлүүлэгчдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотоодоос худалдан авах боломжийг тусгана. Худалдан авалтыг төрөлжүүлж, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг ийнхүү хангаснаар нийлүүлэгчдийг Оюу Толгой ХХК-ийн хэрэгцээ, шаардлагын дагуу өөрийн гэрээ хэрэгжүүлэх чадвар, нийлүүлэх бараа үйлчилгээг илүү оновчтой тодорхойлоход нь тусална. Үүнээс гадна, Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчдийг урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, өөрийгөө санхүүжүүлэх чадвартай болох, уул уурхайн салбарт тогтмол нийлүүлэлт хийх боломжийн талаар илүү ойлголттой болоход нь дэмжлэг болох зорилгоор 3 жилийн худалдан авалтын чиглэлийг гарган ажиллана.

3. **Гэрээ байгуулах эрх олгосны дараах хяналт, шинжилгээ:** Оюу Толгой ХХК нь Тендер шалгаруулалтад амжилттай оролцож чадаагүй нийлүүлэгчидтэй эргэн холбогдож, энэ талаар мэдэгдэнэ. Ингэснээр тэдгээр нийлүүлэгчдийн хувьд сайжруулах шаардлагатай зүйлсийнх нь талаар зөвлөгөө өгч, суралцах боломж олгон, цаашид ижил төстэй шаардлага, нөхцөлтэй тендер шалгаруулалтад оролцоход тэдний өрсөлдөх чадвар сайжрах боломжтой.
4. **Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт:** 20,000 ам.доллараас дээш үнийн дүн бүхий бүх бараа, ажил үйлчилгээний хувьд, мөн (зах зээлийн хүчин зүйлээс хамааран) тогтоосон шаардлага хангасан 3-аас доошгүй нийлүүлэгчээс сонгон шалгаруулалт хийнэ. Ийнхүү өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулах нь үндэсний буюу дотоодын нийлүүлэлтийг хөгжүүлэх, нийлүүлэгчдийг тус бүрийн салбарын чиглэлээр дэмжих, Монгол Улсын хэмжээнд баялгийн тэгш хуваарилалтыг бий болгох, Монголын компаниудын бэлтгэн нийлүүлэлтийн буюу хангамжийн сүлжээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг болно. Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулах боломжгүй нөхцөл байдлыг аль болох багасгах үүднээс шууд худалдан авалт хийх аргыг сонгон ашиглах үйл явцад хатуу шаардлага тавьдаг. Ийнхүү хатуу шаардлага тавьж хязгаарласнаар Оюу Толгой ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын журмаар үйл ажиллагааны худалдан авалтын шаардлагад нийцүүлэн зах зээлд хариуцлагатайгаар оролцож буйг нотлон харуулж чадаж байгаа юм.
5. **Шилдэг нийлүүлэгчдийг шалгаруулах хөтөлбөр:** Гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаа хангалттай түвшинд, үр дүнтэй гүйцэтгэсэн гол нийлүүлэгчдээ үнэлж, шагнадаг энэ хөтөлбөрийг Оюу Толгой ХХК-аас боловсруулсан юм.
6. **Үндэсний нийлүүлэгчдэд чиглэсэн худалдан авалтын төрөл:** Оюу Толгой ХХК-аас Өмнөговь аймгаас авах бүтээгдэхүүн, үйлчилгээний зорилтот төрлийг тодорхойлно. Зорилтот төрлийн талаарх бүх мэдээллийг олон нийтэд жил бүр мэдээлж, Оюу Толгой ХХК-ийн цахим хуудасны худалдан авах ажиллагаатай холбогдох хэсэгт байршуулна. Өрсөлдөөнийг илүү өрнүүлэх үүднээс Өмнөговийн нийлүүлэгчдээс авах тухайн зорилтот төрлийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нь нийт худалдан авалтын 80%-аас хэтрэх ёсгүй болно. Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчдээс авах бүтээгдэхүүн, үйлчилгээний зорилтот төрлийг тодорхойлно. Зорилтот төрлийн талаарх бүх мэдээллийг олон нийтэд жил бүр мэдээлж, Оюу Толгой

ХХК-ийн цахим хуудасны худалдан авах ажиллагаатай холбогдох хэсэгт байршуулна. Өрсөлдөөнийг илүү өрнүүлэх үүднээс үндэсний нийлүүлэгчдээс авах тухайн зорилтот төрлийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нь нийт худалдан авалтын 80%-аас хэтрэх ёсгүй болно.

7. **Тогтвортой нийлүүлэлтийн мастер гэрээ:** Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчидтэй шаардлагатай бол урт хугацааны гэрээ байгуулж болно. Ингэснээр үндэсний нийлүүлэгчид нь шууд худалдан авалтын аргыг хэрэглэх үед олон дахин санал/тендер ирүүлэх шаардлагагүй болно. Урт хугацааны гэрээ байгуулан ажилласнаар үндэсний нийлүүлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, хөрөнгө оруулалт хийхэд нь дэмжлэг үзүүлж, баталгаа гарган өгч буй хэрэг юм.
8. **Гэрээний хөнгөлөлттэй нөхцөл, заалт:** Оюу Толгой ХХК нь үндэсний нийлүүлэгчидтэй хийх гэрээний нөхцөл заалтыг хялбаршуулан хөнгөвчилнө. Харин \$100,000 ам.доллараас дээш үнийн дүнтэй бараа, \$10,000,000 ам.доллараас дээш үнийн дүнтэй барилга угсралтын ажил үйлчилгээний хувьд гэрээний нөхцөл, заалтууд нь олон улсын стандартын дагуу хэвээр үлдэнэ.
9. **Бүх шалгуур үзүүлэлт, чадварын шаардлагыг ижил түвшинд хангасан тохиолдолд үндэсний нийлүүлэгчид давуу эрх олгох** – Хоёр болон түүнээс дээш тооны санал/тендер техникийн хувьд буюу тендерийн баримт бичгийн бүх шаардлагыг хангасан ба хоорондоо үнийн зөрүү нь харьцангуй бага, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны шаардлагуудыг хангаж чадахуйц байгаа бол үндэсний нийлүүлэгчдэд гадаадын нийлүүлэгчдээс илүүтэй давуу эрх олгон, сонгоно.
 - Оюу Толгой ХХК нь дээрх 9 дүгээр зүйлд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа үндэсний нийлүүлэгчдийн дундаас Зураг 2-т үзүүлсэн Нийлүүлэгчийн хөгжлийн үе шатны илүү өндөр түвшинд нь яваа нийлүүлэгчид давуу эрх олгоно.
10. **Үнийн санал өөрчлөх эрх** – Дараах нөхцөлд үндэсний нийлүүлэгчдэд тендерийн үнийн саналаа дахин хянан өөрчлөх боломж олгоно. Үүнд:
 - \$100,000 ам.доллараас дээш үнийн дүнтэй тендерт оролцож байгаа тохиолдолд;
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь техникийн шаардлагыг бүрэн хангаж байгаа тохиолдолд;
 - Үндэсний болон гадаадын нийлүүлэгчийн санал болгосон тендерийн үнийн саналын зөрүү нь 10% дотор байгаа тохиолдолд боломжтой болно.

4. Тайлагнах шаардлага

Оюу Толгой ХХК нь гол сонирхлын бүлгийн талуудад үйл ажиллагааны талаар тайлагнах, гүйцэтгэлийн удирдлагын горимыг баримтлан ажиллах үүрэгтэй бөгөөд энэ нь мөн үүгээр үл хязгаарлагдана.

- Удирдлагад сар бүр тайлагнах;
- ТУЗ-д улирал тутам тайлагнах;
- Жил бүр дотоод аудит хийлгэх.

Тайланд хамгийн багадаа дор дурдсан мэдээллийг заавал тусгах бөгөөд энэ нь мөн үүгээр үл хязгаарлагдана. Үүнд:

- Зарцуулалтын буюу Худалдан авалтын дүн, төрлөөр;
- Өмнөговийн нийлүүлэгчид ба үндэсний болон гадаадын нийлүүлэгчдийн хийсэн худалдан авалт, хувиар;
- Зорилтыг бодит гүйцэтгэлтэй харьцуулсан байдал зэрэг болно.